



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2012 оны 10 сарын 05 өдөр

Дугаар 32

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Авто тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх, “Тээврийн хэрэгслийн оношилгоо, хяналт зохицуулалтын алба” /УТҮГ/, түүний орон нутаг дахь салбар, аймгуудын Тээвэр, автозамын газрууд болон Нийслэлийн нийтийн тээврийн газрын хэрэгжүүлж буй чиг үүрэгт дүгнэлт гарган шинэчлэн тодорхойлох, ажлын уялдаа холбоотой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, давхардал, хийдэлгүй ажиллуулах талаар санал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Х.Ержан

Дэд сайд

Гишүүд:

Н.Сандаг-Очир

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын ахлах референт /тохирсоноор/

Д.Батбаатар

Авто тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын үүрэг гүйцэтгэгч

Б.Жаргал

Зам, тээврийн хяналт, бүртгэлийн газрын даргын үүрэг гүйцэтгэгч

Н.Зориг

“Тээврийн хэрэгслийн оношилгоо, хяналт зохицуулалтын алба” /УТҮГ/-ын дэд захирал

Б.Мандат

Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Зам ашиглалт, засварын хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч

З.Цэрэнчимэг

Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч, Сайдын багцын ерөнхий нягтлан бодогч

Б.Хүрэлбаатар

Стратегийн бодлого, төлөвлөлтийн газрын мэргэжилтэн

Д.Намсрайжав

Хуулийн хэлтсийн мэргэжилтэн

П.Наранцэцэг

Нийслэлийн Нийтийн тээврийн газрын дарга

С.Батболд

Зам, тээврийн хяналт, бүртгэлийн газрын ахлах мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:
Ц.Нэргүйбаатар

Авто тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Автотээврийн бодлого хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч

2. Тушаалын 1-д заасан ажлыг 2012 оны 10 дугаар сарын 15-ны дотор судлан дүгнэлт гаргаж сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч /Х.Ержан /-д даалгасугай.

